

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд найрамдах солонгос улс
ЗТХС	Зам тээврийн хөгжлийн сайд



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ДАРГА Д.БАЯРМАНДАХ  
ТАНАА

᠒᠐᠒᠐.᠐᠒.᠒1 № 06/574  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал

- Тайлант онд ажилчдад түрээсийн байрны барьцааг олгохдоо 3 ажилтанд /3,000.0-3,761.4 мянган вон/ буюу нийт 22,375.0 мянган төгрөгийг тогтоосон хэмжээнээс илүү олгосон;
- 2020 оны батлагдсан төсөвт байрны барьцааг олох зардал батлагдаагүй байхад тус төвийн даргын тушаалаар албан хаагчдад олгох байрны барьцааг нэмж олгохоор шинэчлэн баталсан нь цаашид авлага нэмэгдэх, төсвийн хөрөнгө хүрэлцэхгүй байх эрсдэлтэй;
- Санхүүгийн тайланд тайлагнасан ажиллагсадтай холбоотой нийт 357,403.0 мянган төгрөгийн авлагаас 45,128.5 мянган төгрөгийн 2015-2016 онд үүссэн Монгол улс руу буцсан, ажлаас чөлөөлөгдсөн хүмүүсийн тооцоо нийлж, баталгаажуулаагүй түрээсийн байрны барьцааны авлага байгаа;


зэрэг нь үнэн зөв, эрх үүрэг, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга Д.Баярмандах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн зардлыг бодитой төсөвлөх, төсвийг үр ашигтай зарцуулах, авлагыг барагдуулах, тооцоо нийлж баталгаажуулах, автомашины техник ашиглалтын дэвтэр хөтлөх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дүгээр сарын 10-ноос 2020 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Чанцалдулам хариуцаж хэрэгжүүлэв.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 1/07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь “БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдэд хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудлын хүрээнд хоёр улсын холбогдох хуулийн дагуу хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлыг шийдвэрлэн, нийгмийн даатгалын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж монгол хүний хөгжлийг ахисан түвшинд хүргэх, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад төрийн үйлчилгээг шуурхай үр дүнтэй хүргэнэ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь: Монгол Улс болон Бүгд Найрамдах Солонгос Улс дахь холбогдох яамдын хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамж, гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн үйлчилгээг үзүүлэх, мэдээлэл зөвлөгөөгөөр хангах, чиг үүргийг хэрэгжүүлдэг.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь тайлант хугацаанд Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Монгол улс, БНСУ-ын хөдөлмөрийн яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу БНСУ-д ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээнд хяналт тавьж, биелэлтийг хангуулах, БНСУ-д ажиллаж, амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, “Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 1 дүгээр албан даалгаврыг тус тус хэрэгжүүлэн ажилласан байна.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, 2015 оны “Эдийн засгийн ангилал батлах тухай” 7 дугаар тушаал зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны “БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв”-ийг А/157 дугаар тушаалаар БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн бүтэц, орон тооны хязгаарыг 14 байхаар баталсан байна.

“БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь 2019 оны жилийн эцсийн байдлаар төрийн захиргааны албан хаагч 2, төрийн үйлчилгээний албан хаагч 12 нийт 14 хүн ажиллаж байна.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн;
- БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн даргын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/36 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталсан;

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны А/174 дүгээр тушаалаар батлагдсан бөгөөд Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

БНСУ дахь нийгмийн хамгааллын нэг цэгийн үйлчилгээний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ны нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "бага" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 757,896.3 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 15,157.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,204,275.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцож 24,085.5 мянган төгрөгөөр тогтоосон нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,324.5 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Мөнгөн хөрөнгө</b>			
Авлага	383,985.8	357,403.0	(26,582.8)
Бараа материал	10,071.1	12,538.6	2,467.5
Үндсэн хөрөнгө	231,778.3	231,778.3	-
Хуримтлагдсан элэгдэл	(153,415.1)	(175,624.3)	(22,209.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>472,420.1</b>	<b>426,095.6</b>	<b>(46,324.5)</b>
Өр төлбөр	15.5	-	(15.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	472,404.6	426,095.6	(46,309.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>472,420.1</b>	<b>426,095.6</b>	<b>(46,324.5)</b>

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 26,582.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд авлагыг нийт 130,091.5 мянган төгрөгөөр бууруулснаас 75,741.5 мянган төгрөг нь ажлаас чөлөөлөгдсөн шүүхийн шийдвэртэй 3 хүний авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Тайлант оны эцэст 45,128.5 мянган төгрөгийн 2015-2016 онд үүссэн Монгол улс руу буцсан, ажлаас чөлөөлөгдсөн хүмүүсийн тооцоо нийлж, баталгаажуулаагүй түрээсийн байрны барьцааны авлагын үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 426,095.6 мянган төгрөг болж өмнөх оноос 46,309.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 22,826.0 мянган төгрөгийн сөрөг үзүүлэлттэй, ажлаас чөлөөлөгдсөн шүүхийн шийдвэртэй 3 хүний нийт 75,741.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулахад тухайн үед бүртгэсэн ханшийн зөрүүний 23,482.9 мянган төгрөгийн алдагдал хүлээсэнтэй холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,175,037.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,170,399.6 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 4,637.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 88,360.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 14,709.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 73,651.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

Санхүүгийн байдлын тайлангийн тайлант оны эхний үлдэгдлийг өмнөх оны аудит хийсэн санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган шалгахад бараа материалын дансны үлдэгдэл нийт дүнгээрээ зөрүүгүй ч бараа материалын төрлөөрх дансдын эхний



үлдэгдлүүд хоорондоо гүйгдэж, 10,071.1 мянган төгрөгөөр хооронд нь зөрүүлэн тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан маягтаар хийгээгүй, хөтөлбөр зориулалт болон төсвийн хэлбэлзлийн тайлан, тохируулгын тайлан бэлтгээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 4,638.0 мянган төгрөгийг тохируулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийг зөрчсөн, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланг залруулсан.

Аудитаар илэрсэн 73,651.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь байгууллагын цахим хуудас [mof.gov.mn](http://mof.gov.mn) сайтад шилэн дансны цэсийг холбож “Шилэн дансны тухай” хуульд заасны мэдээллийг тухай бүр бүрэн оруулж хэвшсэн байна. Тухайлбал: Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ, санхүүжилт зэрэг мэдээллийг тухай бүр нь байршуулж, мэдээлсэн байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 86,505.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс хэрэгжилт 100 хувь, мөн нийт 2 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Аудитаар залруулагдаагүй 73,651.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 24,085.5 мянган төгрөгийн материаллаг түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгч байна.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 *Балансын данстай холбоотой асуудал*

##### 3.1.1 Илрүүлэлт:

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн даргын 2018 оны А/09 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.1.2-т "Төв нь албан хаагчийг орон байраар хангахад төрөөс дэмжлэг үзүүлэх (61.1.5) зорилгоор ажилтан албан хаагчдад байрны барьцааны мөнгө олгоно. Төвийн даргад 15,000.0 мянган вон, мэргэжилтэнд 7,000.0 мянган воныг тус тус олгох ба ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд 7 хоногийн дотор байгууллагын дансанд эргүүлэн төлнө" гэж заасан ч тайлант онд ажилчдад түрээсийн байрны барьцааг олгохдоо 3 ажилтанд /3,000.0-3,761.4 мянган вон/ буюу нийт 22,375.0 мянган төгрөгийг тогтоосон хэмжээнээс илүү олгосон байна.

Мөн 2020 оны батлагдсан төсөвт байрны барьцаа олгох зардал батлагдаагүй байхад тус төвийн даргын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/36 дугаар тушаалаар албан хаагчдад олгох байрны барьцааг төвийн даргад 20,000.0 мянган вон, мэргэжилтэнд 12,000.0 мянган вон буюу тус бүр 5,000.0 мянган воноор нэмж олгохоор шинэчлэн баталсан нь цаашид авлага нэмэгдэх, төсвийн хөрөнгө хүрэлцэхгүй байх эрсдэлтэй байна. Энэ нь 2020 оны батлагдсан төсөв, төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-д: "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" заалтуудтай нийцэхгүй байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй, бүртгэлээр тавих хяналт сул байх

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Эрх зүйн актыг боловсруулахдаа батлагдсан төсөвт зардал болон бусад эрх зүйн акттай уялдуулж, улсын төсөвт хүндрэл үүсгэхгүй ажиллах;

### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### 3.2 Балансын данстай холбоотой асуудал

#### 3.2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд 1 харилцагч байгууллага, 13 ажилчин, 3 ажлаас чөлөөлөгдсөн хүмүүстэй холбоотой нийт 357,403.0 мянган төгрөгийн авлага тайлагнагдсаны 12.6 хувь буюу 45,128.5 мянган төгрөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, уг авлага нь 2015-2016 онд үүссэн Монгол улс руу буцсан ажлаас чөлөөлөгдсөн хүмүүсийн түрээсийн байрны барьцааны авлага байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д: “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй, бүртгэлээр тавих хяналт сул байх

#### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, 2015-2016 онд үүссэн түрээсийн байрны барьцааны авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах;

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### 3.3 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

#### 3.3.1 Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4 авто тээврийн хэрэгсэлд нийт 6,147.5 мянган төгрөгийн урсгал засвар, үйлчилгээ хийсэн боловч автомашины техник ашиглалтын дэвтэр хөтлөөгүй нь ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 4 ба 5 дугаар хавсралт, Иж бүрэн байх: аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

#### 3.3.2. Эрсдэл:

Төсөвт зардлыг үр ашиггүй зарцуулах, бүртгэлээр тавих хяналт сул байх

#### 3.3.3. Өгсөн зөвлөмж:

Техник ашиглалтын дэвтрийг бүртгэж, хэвших;

### 3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>394,056,849.30</b>	<b>369,941,607.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>383,985,781.13</b>	<b>357,403,029.42</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	30,281.13	-
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>383,955,500.00</b>	<b>357,403,029.42</b>
33510	Байгууллагаас авах авлага	118,515,500.00	118,500,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	265,440,000.00	238,903,029.42
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>10,071,068.17</b>	<b>12,538,577.58</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>10,071,068.17</b>	<b>12,538,577.58</b>
35410	Бичиг хэргийн материал	144,930.00	212,077.20
35420	Аж ахуйн материал	1,629,468.81	549,937.52
35430	Сэлбэг хэрэгсэл	0	6,339,410.00
35470	Бусад хангамжийн материал	8,296,669.36	5,437,152.86
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>78,363,250.96</b>	<b>56,154,078.22</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>78,363,250.96</b>	<b>56,154,078.22</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>78,363,250.96</b>	<b>56,154,078.22</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	149,111,940.16	149,111,940.16
39204	Хуримтлагдсан элэгдэл	-101,221,603.79	-116,132,797.91
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	47,348,563.31	47,348,563.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,510,595.99	-37,294,969.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,547,808.11	34,547,808.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,912,860.84	-21,426,466.06
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>472,420,100.26</b>	<b>426,095,685.22</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>15,500.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>15,500.00</b>	-
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>15,500.00</b>	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	15,500.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>472,404,600.26</b>	<b>426,095,685.22</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>472,404,600.26</b>	<b>426,095,685.22</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>472,404,600.26</b>	<b>426,095,685.22</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	477,228,478.12	448,921,665.46
51220	Тайлант үеийн үр дүн	-4,823,877.86	-22,825,980.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>472,420,100.26</b>	<b>426,095,685.22</b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,017,693,517.99</b>	<b>1,175,632,759.31</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>12,420,617.99</b>	<b>595,059.31</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>12,420,617.99</b>	<b>595,059.31</b>
120002	Хүүгийн орлого	-	88,936.71
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>12,420,617.99</b>	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,025,920.00	-
120009	Бусад орлого	394,697.99	506,122.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,005,272,900.00</b>	<b>1,175,037,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,005,272,900.00</b>	<b>1,175,037,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,005,272,900.00	1,175,037,700.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,024,406,194.35</b>	<b>1,196,634,802.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,024,406,194.35</b>	<b>1,196,634,802.93</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>944,394,023.33</b>	<b>1,092,438,560.93</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>542,772,487.07</b>	<b>765,393,390.02</b>
210101	Үндсэн цалин	542,772,487.07	77,414,998.57
210102	Нэмэгдэл	-	599,805,698.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	88,172,693.42
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>13,058,221.74</b>	<b>18,545,495.58</b>
210201	Тэтгэврийн даатгал	9,015,957.10	13,385,526.38
210202	Тэтгэмжийн даатгал	993,658.29	1,289,992.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	825,361.09	1,031,993.84
210204	Ажилгүйдлийн даатгал	202,112.43	257,998.45
210205	Эрүүл мэндийн даатгал	2,021,132.83	2,579,984.59
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>248,402,161.15</b>	<b>162,741,200.00</b>
210302	Түлш, халаалт	17,002,237.20	3,472,451.60
210304	Байрны түрээс	231,399,923.95	159,268,748.40
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>56,308,045.67</b>	<b>48,343,690.59</b>
210401	Бичиг хэрэг	5,738,771.45	5,223,900.00
210402	Тээвэр, шатахуун	23,552,076.00	22,987,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,214,373.54	17,768,300.00
210404	Ном, хэвлэл	796,682.37	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	57,950.00	406,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,948,192.31	1,957,190.59
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,736,497.97</b>	<b>4,300,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,530.00	629,700.00
210602	Тавилга	3,814,174.87	-
210604	Урсгал засвар	4,897,793.10	3,670,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,216,657.50</b>	<b>4,563,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,216,657.50	4,563,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,150,697.94</b>	<b>54,852,212.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,420,165.44	11,234,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	24,184,214.90	34,266,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,214,285.60	1,916,812.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	122,640.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,971,840.00	1,980,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,237,552.00	4,454,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,749,254.29</b>	<b>33,698,472.74</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,323,240.00	11,489,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,426,014.29	22,209,172.74

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>80,012,171.02</b>	<b>104,196,242.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>99,558,200.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	99,558,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>80,012,171.02</b>	<b>4,638,042.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,012,171.02	4,638,042.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-6,712,676.36</b>	<b>-21,002,043.62</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>25,584,176.46</b>	<b>5,817,107.16</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	25,584,176.46	5,817,107.16
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>23,695,377.96</b>	<b>7,641,043.78</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	23,695,377.96	7,641,043.78
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-4,823,877.86</b>	<b>-22,825,980.24</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөг/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,005,733,530.91</b>	<b>1,181,432,023.21</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>460,630.91</b>	<b>6,394,323.21</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>460,630.91</b>	<b>6,394,323.21</b>
120002	Хүүгийн орлого	-	88,936.71
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>460,630.91</b>	<b>6,305,386.50</b>
120009	Бусад орлого	460,630.91	6,305,386.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,005,272,900.00</b>	<b>1,175,037,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,005,272,900.00</b>	<b>1,175,037,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,005,272,900.00	1,175,037,700.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>995,832,234.97</b>	<b>1,175,037,700.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>995,832,234.97</b>	<b>1,175,037,700.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>915,820,063.95</b>	<b>1,070,841,458.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>542,702,926.42</b>	<b>763,486,746.00</b>
210101	Үндсэн цалин	460,213,426.42	101,947,249.84
210102	Нэмэгдэл	-	573,366,802.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	82,489,500.00	88,172,693.42
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>13,013,154.40</b>	<b>18,538,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,013,154.40	17,254,537.41
210202	Тэтгэмжийн даатгал	-	321,040.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	256,832.51
210204	Ажилгүйдлийн даатгал	-	64,208.13
210205	Эрүүл мэндийн даатгал	-	642,081.28
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>248,040,027.15</b>	<b>162,799,200.00</b>
210302	Түлш, халаалт	16,949,046.70	3,472,451.60
210303	Цэвэр, бохир ус	-	-
210304	Байрны түрээс	231,090,980.45	159,326,748.40
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>54,794,155.84</b>	<b>48,862,000.00</b>
210401	Бичиг хэрэг	5,535,898.70	5,223,900.00
210402	Тээвэр, шатахуун	23,552,076.00	22,987,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,214,373.54	17,768,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	57,950.00	406,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,433,857.60	2,475,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,767,583.10</b>	<b>6,249,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	869,790.00	629,700.00
210604	Урсгал засвар	4,897,793.10	5,619,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,216,657.50</b>	<b>4,563,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,216,657.50	4,563,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>38,962,319.54</b>	<b>54,852,212.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,264,405.44	11,234,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	24,151,596.50	34,266,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,336,925.60	1,916,812.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,971,840.00	1,980,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,237,552.00	4,454,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,323,240.00</b>	<b>11,489,300.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,323,240.00	11,489,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>80,012,171.02</b>	<b>104,196,242.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>99,558,200.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	99,558,200.00

<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>80,012,171.02</b>	<b>4,638,042.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,012,171.02	4,638,042.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>9,901,295.94</b>	<b>6,394,323.21</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	-	-
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-	-
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-9,901,295.94</b>	<b>-6,394,323.21</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>6,478,619.39</b>	<b>67,323.32</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	6,478,619.39	67,323.32
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>16,379,915.33</b>	<b>6,461,646.53</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	16,379,915.33	6,461,646.53
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>358,728,478.12</b>	<b>358,728,478.12</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	118,500,000.00	118,500,000.00
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>477,228,478.12</b>	<b>477,228,478.12</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-4,823,877.86	-4,823,877.86
10	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>472,404,600.26</b>	<b>472,404,600.26</b>
11	<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>472,404,600.26</b>	<b>472,404,600.26</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-23,482,934.80	-23,482,934.80
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>448,921,665.46</b>	<b>448,921,665.46</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	-22,825,980.24	-22,825,980.24
20	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>426,095,685.22</b>	<b>426,095,685.22</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,175,037,700.00</b>	<b>1,170,399,658.00</b>	<b>4,638,042.00</b>	<b>99.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,175,037,700.00</b>	<b>1,170,399,658.00</b>	<b>4,638,042.00</b>	<b>99.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,075,479,500.00</b>	<b>1,070,841,458.00</b>	<b>4,638,042.00</b>	<b>99.6</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>763,487,300.00</b>	<b>763,486,746.00</b>	<b>554.00</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	50,699,500.00	101,947,249.84	-	201.1
210102	Нэмэгдэл	615,823,200.00	573,366,802.74	42,456,397.26	93.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	96,964,600.00	88,172,693.42	8,791,906.58	90.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,538,700.00</b>	<b>18,538,700.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,167,900.00	17,254,537.41	913,362.59	94.9
210202	Тэтгэмжийн даатгал	92,700.00	321,040.67	-228,340.67	346.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	74,200.00	256,832.51	-182,632.51	346.1
210204	Ажилгүйдлийн даатгал	18,500.00	64,208.13	-45,708.13	347.1
210205	Эрүүл мэндийн даатгал	185,400.00	642,081.28	-456,681.28	346.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>162,799,200.00</b>	<b>162,799,200.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210302	Түлш, халаалт	14,124,000.00	3,472,451.60	10,651,548.40	24.6
210304	Байрны түрээс	148,675,200.00	159,326,748.40	-	107.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>48,862,000.00</b>	<b>48,862,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	5,223,900.00	5,223,900.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	22,987,800.00	22,987,800.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,768,300.00	17,768,300.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	406,500.00	406,500.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,475,500.00	2,475,500.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,249,400.00</b>	<b>6,249,400.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	903,400.00	629,700.00	273,700.00	69.7
210604	Урсгал засвар	5,346,000.00	5,619,700.00	-273,700.00	105.1
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,563,900.00</b>	<b>4,563,900.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210701	Гадаад албан томилолт	-	-	-	-
210702	Дотоод албан томилолт	4,563,900.00	4,563,900.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>59,489,700.00</b>	<b>54,852,212.00</b>	<b>4,637,488.00</b>	<b>92.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,536,000.00	11,234,300.00	301,700.00	97.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	-	1,500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	34,266,900.00	34,266,900.00	-	100.0

210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,752,600.00	1,916,812.00	2,835,788.00	40.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,980,000.00	1,980,000.00	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,454,200.00	4,454,200.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,489,300.00</b>	<b>11,489,300.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	0	-	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,489,300.00	11,489,300.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>99,558,200.00</b>	<b>99,558,200.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>99,558,200.00</b>	<b>99,558,200.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	99,558,200.00	99,558,200.00	-	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,175,037,700.00</b>	<b>1,170,399,658.00</b>	<b>4,638,042.00</b>	<b>99.6</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,175,037,700.00</b>	<b>1,170,399,658.00</b>	<b>4,638,042.00</b>	<b>99.6</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,175,037,700.00	1,170,399,658.00	<b>4,638,042.00</b>	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		
610001	Төсвийн байгууллага	1	1		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>14</b>	<b>12</b>	<b>2.00</b>	
620001	Удирдах ажилтан	2	2		
620002	Гүйцэтгэх ажилтан	12	10	2.00	
620003	Үйлчлэх ажилтан	0	0		
620004	Гэрээт ажилтан	0	0		

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020.02.20			САГ-2020/1/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	<p>БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн даргын 2018 оны А/09 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.1.2-т "Төв нь албан хаагчийг орон байраар хангахад төрөөс дэмжлэг үзүүлэх (61.1.5) зорилгоор ажилтан албан хаагчдад байрны барьцааны мөнгө олгоно. Төвийн даргад 15,000.0 мянган вон, мэргэжилтэнд 7,000.0 мянган вонг тус тус олгох ба ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд 7 хоногийн дотор байгууллагын дансанд эргүүлэн төлнө" гэж заасан ч тайлант онд ажилчдад түрээсийн байрны барьцааг олгохдоо 3 ажилтанд /3,000.0-3,761.4 мянган вон/ буюу нийт 22,375.0 мянган төгрөгийг тогтоосон хэмжээнээс илүү олгосон байна.</p> <p>Мөн 2020 оны батлагдсан төсөвт байрны барьцаа олгох зардал батлагдаагүй байхад тус төвийн даргын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/36 дугаар тушаалаар албан хаагчдад олгох байрны барьцааг төвийн даргад 20,000.0 мянган вон, мэргэжилтэнд 12,000.0 мянган вон буюу тус бүр 5,000.0 мянган воноор нэмж олгохоор шинэчлэн баталсан нь цаашид авлага нэмэгдэх, төсвийн хөрөнгө хүрэлцэхгүй байх эрсдэлтэй байна.</p>	22,375.0	Зөвлөмж	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга  Нягтлан бодогч	Д.Баярмандах  Я.Гармаа
2	Санхүүгийн тайланд 1 харилцагч байгууллага, 13 ажилчин, 3 ажлаас чөлөөлөгдсөн хүмүүстэй холбоотой нийт 357,403.0 мянган төгрөгийн авлага тайлагнагдсаны 12.6 хувь буюу 45,128.5 мянган төгрөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, уг авлага нь 2015-2016	45,128.5	Зөвлөмж	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга	Д.Баярмандах

	онд үүссэн Монгол улс руу буцсан ажлаас чөлөөлөгдсөн хүмүүсийн түрээсийн байрны барьцааны авлага байна.			Нягтлан бодогч	Я.Гармаа
3	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4 авто тээврийн хэрэгсэлд нийт 6,147.5 мянган төгрөгийн урсгал засвар, үйлчилгээ хийсэн боловч автомашины техник ашиглалтын дэвтэр хөтлөөгүй байна.	6,147.5	Зөвлөмж	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга  Нягтлан бодогч	Д.Баярмандах  Я.Гармаа





